

ТӨСЛИЙН ТОВЧООН

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ

2014 оны 4-р сар



Implemented by:



БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр

Эрчим хүчний хэмнэлтэд төсвөөс хөрөнгө оруулах нь төсөл

Хэрэгжүүлэх хугацаа:
2014-2016 он

Нийт санхүүжилт:

10 сая швейцарь франк
Швейцарийн хөгжлийн агентлаг
- 5 сая шв.франк
ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн яам
- 5 сая шв.франк

Зорилтот бус нутаг:

Ховд болон Завхан аймаг

Зорилтот бүлэг:

Ховд, Завхан аймгийн иргэд, хүүхдүүд болон эцэг эхчүүд, орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн компаниуд

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТЭД ТӨСВӨӨС ХӨРӨНГӨ ОРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

“Эрчим хүчний хэмнэлтэд төсвөөс хөрөнгө оруулах нь” төсөл Монгол улсын алслагдсан баруун хоёр аймагт (Ховд, Завхан) барилгын дулааны алдагдлыг бууруулж, эрчим хүчний хэмнэлтийг дээшлүүлэхэд нэн шаардлагатай хөрөнгө оруулалтыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр болон Төсвийн тухай шинэ хуулиар орон нутагт хуваарилж эхлээд буй Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдэх боломжтойг харуулах зорилготой төсөл юм.

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн (ГОУХАН) хэрэгжүүлж буй энэ төсөл нь орон нутагт санхүүжүүлэх шаардлагатай төслүүдийг төлөвлөх болон төсөвлөх үйл явцад иргэдийн идэвхитэй оролцоог дэмжин улмаар орон нутгийн иргэдийн тав тухтай амьдрах нөхцлийг сайжруулахад хувь нэмрээ оруулна.



ҮНДЭСЛЭЛ

Эрс тэс уур амьсгалтай Монгол оронд, ялангуяа хөдөө орон нутагт эмнэлэг, сургууль гэх мэт нийтийн үйлчилгээний газруудыг социалист нийгмийн үеийн хуучирсан, дулааны алдагдал ихтэй хуучны халаалтын системээр халаадаг хэвээр байна. Иймд, хөдөө орон нутагт иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, эдийн засгийн хөгжлийг хангахын тулд эрчим хүчний хэмнэлттэй технологийг дээрх барилга

байшинд нэвтрүүлэх, засвар үйлчилгээ хийх нь нэн тулгамдсан асуудал болоод байна. Ингэхдээ төсвийн төвлөрлийг сааруулах чиглэлээр, ялангуяа орон нутгийн төсвийн зарцуулалт, худалдан авалт, хяналтыг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор зохион байгуулахыг эрмэлзэж буй санаачлагатай уялдуулснаар төрийн санхүүгийн менежментийг сайжруулахад ач холбогдолтой юм.

ШХА-ийн зорилго:


Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорино.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн гол зорилго нь иргэдийн оролцоотойгоор гарсан шийдвэрийг үндэслэн орон нутгийн төсвийн хөрөнгийн санхүүжилтээр нийтийн зориулалттай барилга байшигийн дулааны алдагдлыг бууруулах замаар хөдөө, орон нутагт хүн амьдрах, ажиллас нөхцлийг сайжруулах явдал юм.

ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- Төсөл нь орон нутгийн удирдлага, засаг захиргаа болон иргэдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэн төвлөрлийг сааруулах, эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Нийтийн барилга байшингийн дулааныг сайжруулахад төслийн хүрээнд болон хамтарсан эх үүсвэрээс хөрөнгө оруулалт хийх бөгөөд орон нутгийн удирдлагуудад төрийн санхүүгийн менежментийн ур чадварыг бодит жишээн дээр хэрэгжүүлэх боломж олгоно.
- Төсөл нь аймаг, сум орон нутгийн түвшинд хүүхдийн сургууль, цэцэрлэгийн барилгыг сайжруулан, дулаан тусгаарлалт хийж дулааны алдагдалгүй, эрчим хүчний хэмнэлт, үр ашиг гаргахын ач холбогдол, давуу талыг олон нийтэд танилцуулж, тэднийг мэдлэг, мэдээлэлтэй болгоход анхаарна.
- Төсөл хэрэгжиж дууссаны дараа ч эрчим хүчний хэмнэлтийн мэргэжлийн ажил, үйлчилгээг тогтвортой, үр дүнтэй үргэлжлүүлэх чадавх бүхий бүтцийн өөрчлөлтийг төслөөс дэмжихийн зэрэгцээ аймгийн засаг захиргаа, аймаг дахь техникийн ажлын хэсгүүд, Эрчим хүчний зохицуулах хороо, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд, Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагатай хамтарч ажиллана.
- Төсөл нь эрчим хүчний хэмнэлтийн чиглэлээр бодлогын түвшинд үйл ажиллагаа явуулдаг ГОУХАН-ийн "Эрчим хүчний системийн үр ашиг" хөтөлбөрөөр дамжуулан хэрэгжих юм. Мөн түүнчлэн орон нутагт хэрэгжүүлсэн ажлын туршлага дээрээ үндэслэн эрчим хүчний үр ашиг, төрийн санхүүгийн менежмент болон төвлөрлийг сааруулах чиглэлээр хууль, эрх зүй, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах зөвлөмж боловсруулна.



Ховд аймгийн сургуулийн барилгын дулаан хэмжилт

- Төслөөс орон нутагт төсвийн санхүүжилтэд "ашиглалтын нийт хугацаа"-г харгалзан зардал тооцох аргачлал болон нийтийн зориулалттай барилга байшинг сэргээн засварлах төслийг боловсруулах, удирдлага зохицуулалтаар хангах, хамтарсан санхүүжилт хийх зэрэг арга замыг танилцуулах болно.
- Эрчим хүчний мэргэжлийн ажил үйлчилгээний эрэлт хэрэгцээ нэмэгдэхийн хэрээр энэ чиглэлийн хувийн салбарын нийлүүлэлт нэмэгдэнэ гэж төсөл үзэж байна.

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- Нийтийн зориулалттай барилгын дулаалга, эрчим хүчний үр ашгийг дээшлүүлснээр төрийн үйлчилгээ сайжрахад нөлөөлнө. Шинээр барилга барих, түүнчлэн хуучин барилгыг сэргээн засварлахад эрчим хүчний хэмнэлт бүхий шинэ материал, технологи ашиглах нь төрийн үндсэн үйлчилгээг чанаржуулахад бодитой дэмжлэг үзүүлнэ. Эмнэлгийн байгууллагууд хүйтний улиралд сайн халаалттай, дулаалга сайтай өвөлжих нь эмчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээг сайжрах, мөн сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн дулаалгыг сайжруулах нь хүүхэд багачууд илүү тав тухтай орчинд суралцах зэрэг эерэг үр дүнг авчирна.

- Иргэдийн оролцоотойгоор эрчим хүчний үр ашигт хөрөнгө оруулалт хийх нь төвлөрлийг сааруулах бодлогыг эрчимжүүлнэ. Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн хөгжлийн санд хуваарилж буй хөрөнгийг иргэдийн оролцоотойгоор тухайн аймаг, сумын төсвийн хөрөнгөөр эрчим хүчний хэмнэлттэй материал, тоноглол бүхий нийтийн зориулалттай шинэ барилга байшин барих эсвэл хуучин барилгыг сэргээн засварлахад ашиглах нь төвлөрлийг сааруулах үйл явцыг дэмжих юм.

- Төсөл нь орон нутгийн засаг захиргаа, компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд болон иргэдэд аливаа төсөлд хөрөнгө оруулалт хийхэд ашиглалтын нийт хугацааны зардлыг тооцож сурах, төрийн санхүүгийн менежментийн мэдлэг, ур чадвартай болох, эрчим хүчний хэмнэлттэй холбоотой асуудлыг шийдэх практик дадал эзэмших зэрэг боломж олгох болно.

Хамтран хэрэгжүүлэх түншүүд:

- Засгийн газрын хэрэг эрхлэх газар
- Эрчим хүчний яам
- Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
- Сангийн яам
- Ховд, Завхан аймгийн засаг захиргаа
- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүд

Холбоо барих:

Эрчим хүчний хэмнэлтэд төсвөөс хөрөнгө оруулах нь төсөл

Найман зовхис төв,
Сөүлийн гудамж 21

Ш/Х: 1264, Улаанбаатар 14251
Монгол улс

Утас: +976 70115340
Факс: +976 11 315342
И-мэйл: giz-mongolei@giz.de
Вэб хуудас: www.giz.de

Монгол дахь Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Скай плаза бизнес төв,
Олимпийн гудамж 12,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Улаанбаатар хот

Ш/Х 37, Улаанбаатар 210648,
Монгол улс

Утас: +976 11 331 422
Факс: +976 11 331 420
И-мэйл: ulaanbaatar@eda.admin.ch
Вэб хуудас: www.swiss-cooperation.admin.ch/mongolia